



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 258

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 53,212,700.00 (тавин гурван сая хоёр зуун арван хоёр мянга долоон зуу) төгрөгийн балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Дундговь аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Дундговь аймгийн Онцгой байдлын газрын дарга Ц.Төрбилэг, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга С.Хулан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Ажлын хэсэг томилон хөрөнгө хүлээлцэх үнийг шинэчлэн тогтоож, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 25. дугаар сарын 25. Одоогийн
дугаар тогтолцоогоор хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон отноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг
1	Лед самбар	2020.12.31	Ш	1	53,212,700.00	53,212,700.00	-
					53,212,700.00	53,212,700.00	-
	Нийт дүн				(тавин гурван сая хоёр зуун арван хоёр мянга долоон зүй)	(тавин гурван сая хоёр зуун арван хоёр мянга долоон зүй)	